

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён Зафер Атеш 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдөр аймгийн Засаг даргын урилгаар тус аймагт албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалтай танилцан, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, Турк улсын муж, хоттой ах дүүгийн найрамдалт харилцаа тогтоон хамтран ажиллах талаар санал солилцлоо. Мөн Элчин сайд Зафер Атешийн зүгээс Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үйл ажиллагаатай танилцаж, нийгмийн салбарын хүрээнд дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаа илэрхийлсэн.

2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Чангвон хотын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, ах дүү найрамдлын харилцаа тогтоох талаар мөн хоёр талын удирдлагууд хот, орон нутгаа танилцуулж, хамтын ажиллагааны чиглэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон байна.

Дэлхийн багш нарын баярын 27 дахь өдөр”, “Монголын багш нарын баярын 55 дахь өдөр, “Орчин цагийн боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 100 жил”-ийн ойн баярын арга хэмжээг 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдөр цахимаар зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, соёл амралтын хүрээлэнд 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Нээлтийн үеэр мод тарих иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг тарьц суулгацаар хангах зорилгоор Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газар болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Модны их ургац ЗБН-тэй хамтран “Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа” зохион байгуулж, 6 төрлийн мод, бутны суулгац худалдаалсан байна. Аймгийн хэмжээнд нийт 33 аж ахуйн нэгж, байгууллагын 700 гаруй албан хаагч, 80 гаруй иргэн 6682 ширхэг мод бутыг тарьсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мод тарьсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо 3.5 дахин, тарьсан модны тоо 1 дахин нэмэгдэж, мод тарих ажилд иргэдийн идэвх санаачилга жилээс жилд нэмэгдэж байна.

2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Онцгой Байдлын Ерөнхий Газрын дэд дарга, Улсын Онцгой Комиссын Нэгдсэн Шуурхай Штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр тус аймагт ажиллалаа. Орон нутагт коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдвар хамгааллын дэглэм сахиулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тайлангаа танилцуулсан байна. Мөн бригадын генерал Б.Ууганбаяраар ахлуулсан ажлын хэсэг аймаг сумын Онцгой комисс, шуурхай штабын үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр хэлэлцэж, үйл ажиллагааг чиглүүлэх, хяналт тавих, зөвлөмж өгч ажиллалаа. Мөн Говьсүмбэр аймгийн шуурхай штабын үйл ажиллагаатай биечлэн танилцаж, заавар зөвлөгөө өгсөн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 192,2 сая төгрөгийн 22 нэр төрлийн PCR шинжилгээний тоног төхөөрөмж, 31,0 сая төгрөгийн оношлуурыг хүлээлгэн өгч суурилуулснаар 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлж, орон нутагт полимеказын гинжин урвалын шинжилгээг хийж эхлээд байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн яамнаас Коронавирусын халдвартай үйлчлүүлэгчид мэс засал хийхэд шаардлагатай унтуулгын аппаратаар хангасан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхааран ажиллаж байна.

2021 оны 10 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 6 321 251 мянган төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6 291 319 мянган төгрөг төвлөрүүлж, 122 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 999 544 мянган төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 999 544 мянган төгрөг төвлөрүүлж, 100 хувь, сумын төсвийн орлогод 715 452 мянган төгрөг төвлөрүүлэхээс 872 381 мянган төгрөг төвлөрүүлж, 121 хувь, аймгийн төсвийн орлогод 4 606 255 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5 112 815 мянган төгрөг төвлөрүүлж, 110 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Оны эхэнд татвар төлөгчийн тоо 629 байсан ба 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 29 татвар төлөгч хуулийн этгээд нэмэгдэж, нийт 658 болсон байна. Татвар төлөгчдийг хариуцлагын хэлбэрээр харуулбал ХК-1, ХХК-342, ББН-5, ЗБН-9, Хоршоо-24, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-64, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-206 байна.

Татварын ерөнхий газрын даргын олгосон томилолтын дагуу 3 аж ахуй нэгжид 2017-2020 оны татвар, санхүүгийн баримт материал, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 216 629 880 төгрөгийн зөрчил илрүүлэн, 33 862 119 төгрөгийн нөхөн ногдуулалтын акт үйлдэн ажилласан.

Статистикийн чиглэлээр: Мал төллөлт бойжилтын ХАА-1, Том малын зүй бус хорогдлын ХАА-2, ХАА-н бүтээгдэхүүний үнийн ХАА-3, Ургац хураалт хадлан тэжээлийн ХАА-8, Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгийн үнийн ХАА-10 мэдээг, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн АҮ-1 мэдээ, Барилга байгууламжийн ББО-1, ББӨ-1, Радио телевизийн үйлчилгээний МХХ-1, Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны ХУ-1, Худалдааны салбарын үнийн ХСҮ-1, сар бүрийн 21-ний өдрийн үнийн мэдээ, мэдээллийг хугацаанд нь тус тус ҮСХорооны төв серверт дамжуулсан.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 96,7 хувь буюу өмнөх сараас 4,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.10.25		2021.10.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/
1	Өндөр настан	1837	8049911,6	1934	8899021,2
2	Хөгжлийн бэрхшээлтэй	334	1199008,9	314	1049307,6
3	Тэжээгчээ алдсан	131	407044,3	128	415767,4
4	Үйлдвэрийн осол	27	137570,8	46	247418,6
Нийт дүн		2329	9793535,6	2422	10611514,8

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.10.25		2021.10.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	1137	155407,1	1213	143147,5
2	ЖБА тэтгэмж	331	588035,1	388	773398,6
3	Оршуулга	60	60000,0	79	79000
4	ҮОМШӨ-ХЧТА	7	6306	14	13024,8

5	Ажилгүйдэл	164	346461,0	181	310376,2
	Нийт дүн	1699	1156209,2	1875	1318947,1

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.10.25	2021.10.25
Шинээр	325	230
Мөнгө тушаасан	504	522
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	108357,5	169127,3

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 26
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 66
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 5
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 1
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 8
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 22
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 15

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 12
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 23
- Гэрээний бүртгэл - 37
- Барьцааны гэрээний бүртгэл - 87
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 3

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 10

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 34
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 264

Нийт 651 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс: Тайлант сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 106 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 20, зөрчлийн 86 гомдол байна. Тайлангийн хугацаанд зөрчил гаргасан 763 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 28,595,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 56 хүнийг эрүүлжүүлж, 11 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 24 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нутаг дэвсгэрт эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 240 алба хаагч 1920 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, заавар зөвлөгөө өгч ажилласан.

Сүмбэр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран архины хамааралтай иргэдтэй уулзаж, нэгдсэн судалгааг шинэчлэн гаргах, дараагийн холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Таныг сонсьё” арга хэмжээг 10 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд зохион байгууллаа.

2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар төмөр замын Чойр дахь Замын 3 дугаар ангийн 185 ажилтанд “Гэмт хэрэг, зарчлоос урьдчилсан сэргийлэх тухай, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, хохирогч, холбогдогч нарын сэтгэл зүйн онцлог” сэдвүүдээр цахим сургалт зохион байгууллаа.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 26 удаа оролцоноос зам тээврийн ослын 8, хулгайлах гэмт хэрэг 3, бусад хэргийн газрын үзлэгт 15 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 135 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”, аймгийн Уул, уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтэй хамтран гагнуурчин, цахилгаанчин, хүнд машин механизмын оператор, зам барилгын машин механизмын оператор мэргэжлээр шинээр 40 хүмүүжигчийг элсүүлж, 44 хүмүүжигч төгсгөж мэргэжлийн үнэмлэх олгосон.

2021 оны 10 дугаар сард төлбөрийн 227 гүйцэтгэх баримт бичгийн 3617690,1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 108 баримт бичгийн 909763,7 мянган төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 47.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мэргэжлийн хяналтын газар: Иргэн аж ахуй нэгжээс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу 1 иргэнд 150,000 төгрөгийн торгууль, 2 аж ахуй нэгжид 8000,0 төгрөгийн торгууль ногдуулж, хяналт шалгалтын явцад илрүүлсэн 2 зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдэж, 2 иргэнийг 500 нэгжээр торгож, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан даалгаврыг хүргүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын А/114 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах, коронавируст халдварын цар тахлын тандалт, албан байгууллагын дотор өвчлөл тархахаас урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, дотоод хяналтыг тогтмолжуулах зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшүүлэх сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон Говьсүмбэр аймаг дахь Политехникийн коллежтой хамтран зохион байгуулсан.

Коронавируст халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдалд Энхтусдэм ӨЭМТөвд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтанд коронавируст халдварын дэгдэлтийн үед хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл, нөөц, хүрэлцээ, хангамж зэргийг асуудлуудыг шалгаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Засаг даргын баталсан 2021 оны 06 дугаар сарын 02-ны А/162 дугаар захирамжийн хэрэгжилт, түр журмын тусгай нөхцөл, шаардлагыг хангуулахаар эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнсний чанар, стандартын хяналтаар үйл ажиллагааг хязгаарлаагүй бүх чиглэлийн худалдаа, үйлчилгээний байгууллага, хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа 11 объектыг хамруулан хяналт шалгалт хийж, 12 зөрчил илрүүлж, зөрчлийн 82 хувийг газар дээр нь арилгуулж, шалгалтад хамрагдсан объектуудад зөрчлийг дахин гаргахгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллах талаар үүрэг чиглэл өгч, тухайн чиглэлийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагын талаар зөвлөмжийг хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын удирдамж, улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар, иргэд, ААНБ-аас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийж улсын байцаагчийн албан шаардлага 5, дүгнэлт 7, акт 4, удирдамж 15, зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөр 3, зөвлөмж 2-ыг тус тус боловсруулж, хяналт шалгалтад хамрагдсан иргэн, ААНБ-уудад хүргүүлсэн.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 6, хүнсний бүтээгдэхүүний 3, хоолны 3, нийт 12 сорьцонд 67 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн. Эерэг үзүүлэлт илрээгүй.

Онцгой байдлын газар нь: Аймгийн Засаг даргын баталсан “Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө”-ний дагуу ААНБ-ын ажилтан, албан хаагчдад Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах аргачлал, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, Газар хөдлөлт, гал түймэр, үер усны осолд авч хэрэгжүүлэх ажил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 118 ажилтан албан хаагч хамрагдсан.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж дадлагажуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ач холбогдлыг хүүхэд, багачуудад таниулан мэдүүлэх зорилготой гамшгийн эрсдэлийг бууруулах ОУ-ын өдрийг “Зөвхөн хамтдаа бид эх дэлхийгээ аварч цадна” уриан дор ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад Онцгой байдлын газрын гал унтраах үндсэн албаны автомашин, туслах албаны автомашин, техник, хэрэгсэл, аврах ажиллагааны багаж зэвсэглэмжийг таниулан сурталчлан ажиллалаа.

2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Төр захиргааны байгууллагуудын 12 хуулийн этгээдэд хяналт, шалгалт зохион байгуулан, 38 зөрчил илрүүлж, 2 зөрчлийг газар дээр нь арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3, танилцуулга 1 хүргүүлэн ажиллав.

Аймгийн засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/266 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон аймгийн хэмжээнд авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудыг тохирлын үнэлгээнд хамруулах, ангилал тогтоолгох ажлыг зохион байгуулах, галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус үзлэг шалгалтыг 2021 оны 9 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд 7 аж ахуй нэгж байгууллагад зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтарсан хяналт шалгалт зохион байгууллаа.

Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье” төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Сүмбэр сум 3 дугаар багийн айд өрхүүд болон Баянтал сумын айл өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг нийт 239 айл өрхөд зохион байгуулж, 166 зөрчлийг илрүүлэн 35 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 132 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч, 587 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж, гэр хорооллын гудамжинд үйл ажиллагаа явуулдаг 6 иргэн, аж ахуй нэгж байгууллагад гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 3, мэдэгдэл 1 бичиж холбогдох газруудад хүргүүлэн ажиллав.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: 2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтын даалгаврын шинжилгээг “Шинжээч багш” нартай хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид хичээл заадаг багш нарт зөвлөмж хүргүүлээ.

Аймгийн “Хэлний бодлогын салбар зөвлөл”-ийн 2021 оны төлөвлөгөөний дагуу, иргэдийн Монгол хэл, бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах зорилгоор зөвлөлийн цахим пэйж хуудсаар дамжуулан шинээр 5 хичээлийг бэлтгэн хүргээд байна.

Өсвөр үеийн хүүхдүүдэд “Цахим хэрэглээний зөв хэрэглээ” болон “Үе тэнгийн дээрэлхэлт, дарамтыг илрүүлэх” сургалтыг 10 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Монголын сэтгэл заслын холбооны сэтгэл зүйч нартай хамтран цахимаар зохион байгуулсан. Тус сургалтад 6-10 дугаар ангийн нийт 315 сурагч хамрагдсан.

“Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ”-нд Шивээговь сумын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж байгаа 43 сурагчийг хамруулсан.

Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 1 дүгээр ангийн багш, сургуулийн өмнөх боловсролын 5 настай хүүхэдтэй ажилладаг нийт 20 багшид “Сургууль бэлтгэгдсэн байдлыг үнэлэх арга зүй” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: “Оролцоод хөгжье” хүүхдийн үндэсний цахим чуулганыг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр цахимаар зохион байгуулсан.

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгох, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Мэргэжил сонголт миний ирээдүй” сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 24 хүүхдэд цахимаар зохион байгуулж, ганцаарчилсан тест оношилгоо, зөвлөгөөг 4 хүүхдэд үзүүлсэн.

Мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээнээс үүсэх үр дагавар ба согтууруулах ундааны талаар үнэн зөв ойлголтыг иргэдэд хүргэх зорилгоор “Хорт зуршлаас татгалзах, донтолтоос сэргийлэх нь” сэдвээр 2 удаагийн сургалтыг Шивээговь сумын зорилтот бүлгийн иргэднд зохион байгуулсан. Тус сургалтад 21 иргэн хамрагдсан.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Засгийн газраас гэр бүлийн чиглэлээр баримтлах бодлого хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв гэр бүлийг бий болгох зорилгоор орон нутгийн зорилтот гэр бүлүүдэд “Гэр бүлийн боловсрол олгох” 8 модуль багц сургалтыг 5 өдөр цахимаар зохион байгууллаа. Тус сургалтад гэр бүлийн туршилтын хөтөлбөрт хамрагддаг 200 гаруй эцэг эх, асран хамгаалагч гэр бүлийн гишүүд хамрагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүжилтээр Сүмбэр сумын хамтарсан багийн кейс шийдвэрлэх үйл ажиллагаанд зориулан 2.0 сая төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүжилтээр зохион байгуулагдаж буй “Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд аймгийн Цагдаагийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран орон нутгийн хэмжээнд хууль сахиулах байгууллага болон боловсролын байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Соёл, урлагийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Ургийн бичгээ бичиж, ураг удмаа хамгаалъя” удирдамжийн дагуу орон нутгийн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд угийн бичгийн сургалтыг зохион байгуулж байна. Тайлант сард төрийн 7 байгууллагын 75 албан хаагч, 90 иргэнд угийн бичиг хөтлөх талаар сургалт зохион байгуулаад байна.

Биеийн тамир,спортын чиглэлээр: 2021 оны 10 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд “Шинэ өнөөдөр” бүрэн дунд сургуулийн нэрэмжит 6 дугаар тэмцээнд аймгаас 14 тамирчин оролцож 1 алт, 3 мөнгө, 2 хүрэл, 3 тусгай байрын шагналаар 3 тамирчин шагнагдсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2020 оны 10 сарын 20	2021 оны 10 сарын 20
Төрсөн эх	362	335
Гэрийн төрөлт	0	3
Амьд төрсөн хүүхэд	366	342
Амьгүй төрөлт	0	1
Нас баралт	65	56
Эмнэлгийн нас баралт	2	19
Хоног болоогүй нас баралт	0	5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	4259	3460
Амбулаторийн үзлэг	85139	67650
Халдварт өвчин	66	1940

“Эрүүл мэндийг дэмжих” арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээг Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран 3 дахь жилдээ мэргэжлийн багийг орон нутагт урьж, зохион байгууллаа.

Коронавирус /Ковид-19/-ын халдварын үед дархлаагаа дэмжих, эрүүл дадал хэвшилд суралцах энгийн аргыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж, 380 иргэнийг хамруулан 6 төрлийн гарын авлагаар хангасан. Мөн хөдөөгийн багийн иргэдийг дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулж, 18-аас дээш насны 160 иргэнийг хамруулж, улирлын томуугийн вакцинд 2-12 насны 24 хүүхдийг хамруулаад байна.

Монголын сэтгэл судлалын мэргэшсэн мэргэжлийн төв ТББ-тай хамтран 30 байгууллагын 30 албан хаагчийг “Ковид -19 халдварын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах арга, эрүүл дадал хэвшилд суралцах, дархлаа дэмжих энгийн аргууд”, “Стресс түүнээс сэргийлэх арга зам”, “Сэтгэл зүйн зөвлөгөө тусламж” сэдвээр сургалт зохион байгуулж, сургагч багшаар бэлтгэлээ.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Ковид -19 халдварын үед өөрийгөө болон бусдыг хамгаалах арга, эрүүл зөв дадал хэвшилд суралцах, дархлаа дэмжих энгийн аргууд” сэдвээр сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд болон 9 байгууллагын 75 албан хаагч хамрагдсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллээр хангах ганцаарчилсан үйлчилгээнд 25 иргэн;
- Ажлын байрны захиалгын бүртгэл – 31 иргэн;
- Ажилд зуучлах үйлчилгээнд:
 - Түр ажлын байр - 22
 - Байнгын ажлын байр – 34
 - Цагийн ажилд - 3 иргэнийг хамруулж, нийт 53 иргэнд ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлсэн.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээний хүрээнд одоогийн байдлаар 5 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, 14 ахмад настан түр ажлын байраар хангагдаж, ажлын мэдлэг, туршлагаа залуу хойч үеийнхэнд зааж сургах, өвлүүлэх төслийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

2021 оны 10 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараахь хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

	Үзүүлэлт	2021.01.01 - 2021.10.19-ний өдрийн байдлаар	
		Хүн/тоо	Мөнгөн дүн
1.	Халамжийн тэтгэвэр	253	178 271 850
2.	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	268	220 837 220
3.	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	245	180 319 500
4.	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	829	25 282 500
5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	150	24 058 900
6.	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	673	64 254 175
7.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж	45	9 333 500
Нийгмийн халамжийн сангийн дүн		2463	702,357,645

“Ахмад настны өдрийн үйлчилгээ”-г аймгийн Ахмадын хороотой хамтран Баянтал, Сүмбэр суманд эхлүүлж, 33 ахмад настныг хамрууллаа.

Дэлхийн цагаан таягтны өдрийг тохиолдуулан Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “АХА” тэмцээн, 100 буудалт даамын тэмцээнийг зохион байгуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 132 өрхийн 673 гишүүнд 64254,1 мянган төгрөгийг олгосон байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 2 иргэн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн зарим сумдад хадланд гарч 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 1350 тн өвс хадаж, үүнээс орон нутгийн малчдад 850 тн-ыг борлуулаад байна.

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харъяа Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 5 төлөөлөл ирж, Сүмбэр суманд аймаг дундын Малх отрын бүсийн орон тооны бус зөвлөлийн хурлыг 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулан, Малх отрын бүсийн бэлчээрийн даацад тохируулан ашиглах, 2021 оны зуншлага, бэлчээрийн ургац, малын гоц халдварт өвчний нөхцөл байдлыг хэлэлцэж, отрын бүс нутагт 3 аймгийн нийт 90,0 мянган толгой мал өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний 55,0 мянган толгой малыг Говьсүмбэр аймгаас, 20,0 мянган толгой малыг Төв аймгаас, 15,0 мянган толгой малыг Дундговь аймгаас өвөлжүүлж, хаваржуулахаар шийдвэрлэсэн. Ингэхдээ Төв аймгийн Сэргэлэн, Дундговь аймгийн Говь-Угтаал сумаас бусад сумдад малын гоц халдварт өвчний эрсдэлтэй байгаа тул тухайн 2 сумын малаас өөр малыг отрын бүс рүү оруулахгүй, гарал үүслийн гэрчилгээ, түүнд дурдсан малын тоо, төрөл зөрүүгүй байх, мал эмнэлгийн байгууллагаас тогтоосон маршрутаар 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш, АДОБАЗ-аас байгуулсан гэрээний үүргээ хэрэгжүүлэн хамтран ажиллах талаар нарийвчлан зохицуулсан журам мөрдөж ажиллахаар шийдвэрлэсэн.

Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх технологит ажил хийгдэж байна. Уг ажлын гүйцэтгэгчээр Сүмбэр сумын Хөдөө, аж ахуйн тасаг, “Сүмбэр Хишигтэн Зоо” МҮТАҮНэгж, “Сүмбэр хонь” ЦСҮТ-тэй гэрээ байгуулан ажиллаж байна.

2021-2022 оны өвөлжилтийн байдал, цаг агаарын аюулт үзэгдэл, малын тарга хүч зэргээс хамааран нийт бог малын хээлтэгчийн 80 хувийг хээлтүүлэгт оруулахаар тооцоход нэг хуцанд 79 хээлтэгч, нэг ухнад 97 хээлтэгч оногдож, хуц-309, ухна-500 дутагдаж байна. Цаашид дутагдаж байгаа хээлтүүлэгчийг биотехнологийн аргаар нөхөх, мөн эрүүл бүс нутгаас хээлтүүлэгч авах, өнжөөн төллүүлэх, заазлалтыг сайн хийж эдийн засгийн эргэлтэнд оруулах зэргээр зохион байгуулж байна.

2021 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр 26,1 га талбайгаас 232,08 тн төмс, 25,84 га талбайгаас 218,3 тн хүнсний ногоо, 11,4 га талбайгаас 35,2 тн тэжээлийн ургамал хураан авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талбайн хэмжээ нь төмс 8,5 га, хүнсний ногоо 26,4 га-аар, хураан авсан ургацын хэмжээ нь төмс 72,68 тн-р, хүнсний ногоо 27,1 тн-р тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 10 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 250-5000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /цул/ 1000 төгрөгөөр, Хонины ястай мах 250 төгрөгөөр, Адууны ястай мах 1000 төгрөгөөр, адууны цул мах 500 төгрөгөөр, Лууван 300 төгрөгөөр, Чинжүү 1500 төгрөгөөр, помидор 3000 төгрөгөөр, өргөст хэмх 4000-5000 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /9-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	11000	9000	-
		Цул	13000	11000	+1000
2	Хонины мах	Ястай	9000	8000	+250
		Цул	11000	10000	-
3	Адууны мах	Ястай	8500	8000	+1000
		Цул	9000	8500	+500
4	Ямааны мах	Ястай	7000	6500	-
		Цул	8500	8000	-
5	Лууван	монгол	2200	1500	+300
		хятад			
6	төмс	монгол	1400	600	-
		хятад			
7	Байцаа	монгол	2000	1800	-
		хятад			-
8	чинжүү	монгол	13000	11000	+1500
		хятад	13000	1100	
9	Манжин	монгол	2000	1800	
		хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	3800-	1500	-
11	Помидор	монгол	13000	8000	+3000
12	Өргөст хэмх	монгол	15000	12000	+4000-5000
13	Элсэн чихэр	монгол	3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-

16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	1200	1150	-
18	Өндөг	Монгол	550	430	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
20	Ургамлын тос	Олейна	8800	7500	-
		Алтан	6500	4500	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутагт Цагаан ус хэмээх газраас хуучин Зөвлөлтийн цэргийн ангийн хээрийн сургуулилын талбай байсан байрлал орчмоос цагаан өнгөтэй, нунтаг төлөвтэй, хурц үнэр бүхий үл мэдэгдэх химийн бодис бороо, үерийн усанд угаагдан газрын хөрснөөс гарч ирсэн байж болзошгүй нөхцөл байдалтайгаар олдсоныг чиг үүргийн байгууллагуудтай хамтарсан ажиллагаа явуулан хлорацтофенон буюу нулимс асгаруулагч химийн хорт бодис болохыг тогтоон орчныг хамгаалалтад авч, Батлан хамгаалах яамны шинжээч мэргэжилтнүүдийн хяналтанд аюулгүй болгосон.

“Хотол чойр” ИНС-тэй байгуулсан хамтран ажиллах батламжийн хүрээнд хогийн сав, мэдээлийн самбарыг Сүмбэр гарден, цэргийн алдар хөшөө орчимд тус тус байршуулан ажилласан.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 10 дугаар сард 8-н хугацааны мэдээг нийт 248, климат агро дундаж мэдээ ХАА-н тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Тайлант сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 39 удаа, мөн шинжилгээг 13 удаагийн дээжинд хийж, дундаж азотын давхар исэл (NO₂) 0.016 мкг/мг сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.013 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: 2021 оны Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас “Газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 тоот тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” шинэчлэн батлагдсан бөгөөд “Газрын харилцаа-цахим үйлчилгээ” сарын аяныг зарлаад байна.

Тус сарын аяны хүрээнд “Мэдээллийн цаг” удирдамжийг боловсруулж, батлуулан www.egazar.gov.mn цахим системийн талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад танхимаар болон цахимаар мэдээ, мэдээллийг хүргэх, гарын авлага тараах, QR кодоор системд нэвтрэх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт 14 байгууллагын 300 орчим албан хаагчдад мэдээлэл хийж, 13 байршилд QR код бүхий 268 гарын авлага тараан сурталчилаад байна. Мөн иргэд өөрсдийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг хэвлэж авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвд “Цахим

үйлчилгээ”-ний хэсэг тохижуулж, гар утасны e-gazaг аппликейшныг суулгах талаар нийт 56 иргэнд заавар, зөвлөгөө өгсөн.

Захиалгат хянан баталгааг хийлгэх шаардлагатай газруудад цахимаар мэдэгдэл тараах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 10 дугаар сарын байдлаар 37 нэгж талбар тайлангаа хийлгэж баталгаажуулсан.

2021 оны 10 дугаар сарын 4-22-ны өдрүүдэд 23 аж ахуйн нэгж байгууллагын 95 барилга байгууламжийн хувийн хэрэгт үзлэг шалгалт хийж, үүрэг даалгавар, зөвлөмжийг өгсөн.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн Сүмбэр сумын 1 дүгээр багийн айл өрхийг гурвалсан үйлчилгээний өндөр хурдны интернетэд холбох ажил, Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн их засварын ажил, Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дотуур байрны барилгын дээвэр засвар, аймгийн Засаг даргын Тамгын газрын дээвэр засвар, Найрамдал хотхоны 8 дугаар байрны өмнөх авто зогсоолын ус зайлуулах системийн ажлуудад Улсын комисс ажиллаж хүлээн авлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор олон нийтийн зориулалттай барилгад Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд Найрамдал хотхонд байрлах төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн барилга, байгууламжид ороход зориулагдсан орц гарц, нормын дагуу байгаа эсэх шинээр хийхэд холбогдох норм, дүрэм стандартын дагуу хэрхэн хийх талаар зөвлөмж өгсөн.

Худалдан авах ажиллагааны талаар: Нийт 6 184 547,3 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 30 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 20 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 16 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 8 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 8 ажил, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлан, 31 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлыг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулан ажиллаж байна.

2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын гүйцэтгэлийг дүгнэхэд 43 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээс 28 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрч гүйцэтгэл 65 хувьтай байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Дорноговь аймгийн Стандарт, Хэмжилзүйн газартай хамтарч сумын төвд үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлчилгээний байгууллагуудад шалгалт хийж, хугацаа хэтэрсэн тохирлын гэрчилгээг сунгах, зөвлөгөө өгөх, жин хэмжүүр тохируулах ажлыг зохион байгуулсан.

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, отор нүүдлээр ирэх иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, малчдын өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд хөдөөгийн малчин өрхүүдтэй уулзалт зохион байгуулсан.

Одоогийн байдлаар суманд 158 мал бүхий малчин өрхийн нийт 93,649 мал намаржиж байгаас 16 өрхийн 31,600 мал отроор өвөлжих төлөвтэй байна.

Сумын хэмжээнд нийт 207,5 тн өвс, 5 тн ногоон тэжээл, 32,5 тн үйлдвэрийн тэжээл, 25.9 тн гар тэжээл, 4,5 тн хужир нөөцөлснөөс сумын аюулгүйн нөөцөд 28.6 тн өвс, 32,5 тн үйлдвэрийн тэжээл бэлтгэсэн байна. Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу өвсний аюулгүйн нөөцийн бэлтгэл 57,2 хувь, тэжээл 162 хувьтай байна.

2021 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар сургууль, цэцэрлэгийн насны нийт 135 хүүхдийг томуу, томуу төст өвчнөөс урьдчилсан сэргийлэх вакцинд хамруулж, вакцинжуулалтын ажил 67,5 хувьтай байна.

Шивээговь сум: Хөдөөгийн багийн иргэдэд төрийн үйлчилгээ болон соёл, спортын үйлчилгээг хүргэх явуулын үйлчилгээг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж 5 байгууллагын 20 гаруй нэр төрлийн үйлчилгээг малчдад хүргэж, гарын авлага сургалтын материал олгосон.

Хур, дан системээр төрийн 54 нэр төрлийн үйлчилгээг 10 дугаар сард 354 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжийн дансанд 276,200 төгрөгийг төвлөрүүлээд байна.

2021 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс сумын Залуучуудын зөвлөлөөс бүх нийтийн их цэвэрлэгээг 7 хоногийн хугацаатай зохион байгуулж, нийт 5,2 га талбайн 12,5 тн хог хаягдлыг 100 гаруй иргэн цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 90 хувийн хэрэгжилттэй байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хашаа хорооны хөрзөн хуулах, мал амьтны хашаа хорооны 18847,8м² талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийсэн. Мөн малчид өөрсдийн хүчээр 711,7 тн өвс, 150,4 тн тэжээл, 27,5 тн гар тэжээл, хужир шүү 61 тн бэлтгэсэн байна.

Сүмбэр сум: Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран хөдөөгийн багийн иргэдэд өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх мэдээлэл хүргэх, бэлчээр ашиглалтын журам танилцуулж, хэлэлцүүлэх мөн соёлын арга хэмжээг хүргэх зорилгоор “Хөдөөгийн багийн иргэдийн өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Тус өдөрлөгт 30 иргэн хамрагдсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 251 малчин өрх өөрийн хэрэгцээнд зориулан 396 тн.өвс, 30тн гар тэжээл, 21.5 тн хужир шүү, 214тн үйлдвэрийн тэжээл бэлтгэн нөөцлөөд байна 42 малчин өрх 176,4 тн өвс худалдан авах захиалгаа өгөөд байна. Сумын аюулгүй нөөцөд 50тн өвс 5.5тн үйлдвэрийн тэжээл бэлтгээд байна.

Ургац хураалтын ажил хугацаандаа явагдаж, 21,5 тн хүнсний ногоо, 26,1 тн төмс нийт 47,6 тн төмс, хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,6 тн-оор нэмэгдсэн үзүүттэй байна.

Сумын Засаг даргын А/198 дугаар захирамжийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд 1,2,3 дугаар багийн нутаг дэвсгэрт золбин нохой устгах ажлыг зохион байгууан 285 золбин нохой устгаж, төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийж ажиллалаа.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР